



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2022.06.22 № 10/1750
танай 2022.05.31-ны № 1/319 -т

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН
АЛБАНЫ ДАРГА О.ЧУЛУУН ТАНАА**

Танаас 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/319 дугаартай албан бичгээр ирүүлсэн Үндэсний геологийн албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу дахин хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулгыг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 2-хуудастай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА

Ц.ОДХҮҮ

1116127151
УХА0580 9129294

1508 05 1250

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Үндэсний геологийн албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Төсвийн ерөнхийлөн захирагч /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд/-аас төсвийн шууд захирагч /Үндэсний геологийн албаны дарга/-тай зөвшилцөн баталсан Үндэсний геологийн албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилго, 21 зорилтын хүрээнд 56 арга хэмжээ тусгагдсан бөгөөд Үндэсний геологийн албанаас 2021 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг шинэчлэн ирүүлсэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус үндэслэн Үндэсний геологийн албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Үндэсний геологийн албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилго, 21 зорилтын 56 арга хэмжээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **86.8** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

№	Зорилтын дугаар	Арга хэмжээний тоо		Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо						Үнэлгээ /хувь/
		ХАХ	ТАХ	100	90	70	50	30	0	
1.	Зорилт 1.1.	5	5	2	3	-	-	-	-	94.0
2.	Зорилт 1.2.	7	7	1	5	1	-	-	-	88.5
3.	Зорилт 1.3.	1	1	-	-	-	1	-	-	50.0
4.	Зорилт 2.1.	4	4	-	4	-	-	-	-	90.0
5.	Зорилт 2.2.	1	1	-	-	1	-	-	-	70.0
6.	Зорилт 3.1.	1	1	-	-	1	-	-	-	70.0
7.	Зорилт 3.2.	1	1	-	-	1	-	-	-	70.0
8.	Зорилт 3.3.	7	7	-	4	3	-	-	-	81.4
9.	Зорилт 3.4.	1	1	-	1	-	-	-	-	90.0
10.	Зорилт 3.5.	1	1	-	1	-	-	-	-	90.0
11.	Зорилт 4.1.	1	1	1	-	-	-	-	-	100
12.	Зорилт 4.2.	5	5	1	3	1	-	-	-	88.0
13.	Зорилт 5.1.	2	2	-	-	2	-	-	-	70.0
14.	Зорилт 5.2.	7	7	2	4	1	-	-	-	90.0

15.	Зорилт 5.3.	3	3	3	-	-	-	-	-	100
16.	Зорилт 5.4.	1	1	1	-	-	-	-	-	100
17.	Зорилт 5.5.	1	1	1	-	-	-	-	-	100
17.	Зорилт 5.6.	2	2	1	1	-	-	-	-	95.0
19.	Зорилт 5.7.	2	2	1	1	-	-	-	-	95.0
20.	Зорилт 6.1.	1	1	-	1	-	-	-	-	90.0
21.	Зорилт 7.1.	2	2	2	-	-	-	-	-	100
Нийт дүн		56	56	16	28	11	1	-	-	86.8

Тайлбар: ХАХ-хэрэгжүүлэх арга хэмжээний тоо, ТАХ-тайлагнасан арга хэмжээний тоо

Дөрөв. Дүгнэлт

Үндэсний геологийн алба нь 2021 онд 4 зорилго, 21 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлсэн ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 86.8 хувиар үнэлэгдэв. Үүнээс “үр дүнтэй” 5, “тодорхой үр дүнд хүрсэн” 15 зорилт байна.

Гадаад болон олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төслийг удирдан хэрэгжүүлэх, судалгаа-шинжилгээ хийх, холбогдох бүтээл хэвлүүлэх, салбарын үйлдвэрлэл-шинжлэх ухааны хөгжлийн бодлогын санал боловсруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Геологичдын ур чадварыг дээшлүүлэх онолын сургалтыг танхимаар /онлайн/ болон дадлагажуулах хээрийн богино хугацааны сургалт зохион байгуулах арга хэмжээ нь “Эрчимжүүлэх шаардлагатай” байна.


Тав. Санал, зөвлөмж

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг зохих хугацаанд бүрэн гүйцэд тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох журмын дагуу хийж ирүүлэх,
- Шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг чанарын болон тоон үзүүлэлтээр тодорхойлох,
- Гүйцэтгэлийн тайлангийн чанар, утга найруулгыг хянаж, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг бичих, нэг арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг 2000 тэмдэгтэд багтааж тайлагнах,
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 2017 дугаар журмаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-д нийцүүлэн, тавигдах шаардлага болон аргачлалын дагуу боловсруулах.

Хянасан:
ХШУДАГ-ын дарга

 Ц.Одхүү

Үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан:

ХШУДАГ-ын мэргэжилтэн  Ж.Энхсайхан

2/21

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхтуяа

Холбоо барих утас: 70181208

Цахим шуудан: b.munkhtuya@ngs.gov.mn